



65 Page



66 Page



67 Page



68 Page



69 Page

Иаков2

-Jacob2-

Тайлбарлагч Иаков, ахынхаа ууган хүүгийн эрх болон ерөөлийг мэхлэн авснаасаа болж ахдаа үзэн ядагджээ. Тэр ахаасаа холдон зугтаж, хол замд гарахаас өөр аргагүй байв. Нагац ах Лабаных тэднийхээс их хол амьдардаг байжээ. Иаковын сэтгэл ихэд түгшин сандарч байв.

.....

Тайлбарлагч Хав харанхуй шөнө болж, Иаков чулуу дэрлэн хээр талд унтахаар хэвтэв. Тэгтэл Иаков нэгэн зүүд зүүдэлжээ. Зүүдэнд нь, газар дээр нэгэн шат босож, түүний орой нь тэнгэрт тулан, бас дахин харвал, түүгээр Бурханы тэнгэр элч нар өгсөн уруудан байлаа. Гэтэл Бурхан түүний дээр зогсоод ингэж хэлэв.

Бурхан "Иаков! Би бол Эзэн. Чиний хэвтэж байгаа газрыг Би чамд болон чиний үр удамд өгнө. Чиний үр удам газрын шороо шиг олон болж, чи хаана ч байсан Би чамайг хамгаалан, чамайг дагуулах бөгөөд чамайг орхихгүй"

.....

Тайлбарлагч Зүүднээсээ сэрсэн Иаков ихэд гайхширав. Үнэхээр сонин зүүд байлаа.

Иаков "Бурхан минь, Танд баярлалаа!"

Тайлбарлагч Иаков босонгуутаа дэрлэж байсан чулуугаа аван, Бурханд талархал өргөөд тэр газрыг Бетел гэж нэрлэжээ.

.....

Тайлбарлагч Иаков яван явсаар нагац ахындаа иржээ. Иаков нагац ах Лабаны охин Рахелд анхны харцаар дурлав. Тэгээд тэр Лабанд хандан.

Иаков "Ах минь, бага охин Рахелаа надтай гэрлүүлээч. Оронд нь долоон жилийн турш танд зарцлагдъя"

Тайлбарлагч Цаг хугацаа өнгөрсөөр нэг л мэдэхэд долоон жил өнгөрчээ. Тэр Рахелд хайртай учир энэ урт хугацааг тэвчиж чаджээ.

.....

Тайлбарлагч Иаков Лабанд хандан.

Иаков "Хэлсэн ёсоороо долоон жил болсон тул Рахелтай гэрлүүлээч."

Тайлбарлагч Гэвч Лабан Рахелыг биш, түүний том эгч Леаг түүнтэй гэрлүүлэв. Тэгээд эгчээсээ урьтаж дүү нь гэрлэх ёсгүй гэж тайлбарлав. Лабан Иаковт хандан ингэж хэлжээ.



70 Page



71 Page

Лабан “Чи үүний төлөө дахин долоон жилийг гүйцээ. Тэгээд би чамд Рахел охиноо өгье.

Тайлбарлагч Иаков түүний үгэнд итгэн дахин долоон жил хичээнгүйлэн ажиллав. Ингээд хайртай Рахелтайгаа гэрлэжээ.

.....

Тайлбарлагч Иаков Леа болон Рахелтай гэрлэн олон хүүхэдтэй болов. Тэрээр Лабаны гэрт амьдарч байхдаа маш сайн ч ажиллаж байсан бөгөөд мал сүрэг нь ч үржин олширчээ. Ийнхүү Бурханы ерөөлөөр Иаков хөрөнгө чинээтэй нэгэн болжээ.